



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ХЭРЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/28

Чингис хот

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээг бусдад
шилжүүлэх тухай

Монгол улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль"-ийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.4, 38.6, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу үр тарианы усалгаатай тариалангийн зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн өргөдөл гаргасан иргэн Д.Баттөрийн холбогдох бичиг баримтыг үндэслэн газар эзэмших эрхийн гэрчилгээг 1 дүгээр хавсралтад дурдсанаар 1 иргэний 2 нэгж талбарыг шилжүүлсүгэй.

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлэн авсан иргэдэд газар эзэмших эрхийн гэрчилгээг олгож, гэрээ байгуулан биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг газрын мэргэжилтэн (Ц.Зулжаргал)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбоотойгоор сумын Засаг даргын 2020 оны а/268 дугаар, 2022 оны а/14 дүгээр захирамжийн дээрх иргэдэд холбогдох заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Д.ЭРДЭНЭБААТАР

Хэрлэн сумын Засаг даргын 2025 оны
01 дугаар сарын 10-ны өдрийн 728
дугаар захирамжийн хавсралт

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
бусдад шилжүүлэх нэрсийн жагсаалт

Д/ Д	Шилжүүлсэн хүний эцэг/эх/- ийн нэр, нэр	Газрын зориулалт	Газрын хэмжээ	Эзэмшил газрын байршил	Шилжүүлэн авсан иргэн ААНБ-ын нэр	Хугацаа	Шилжүүлэх үндэслэл
1	Далхжав Баттөр /ДО79080318/	Үр тарианы усалгаатай тариалан	930000 м2	Хэнтий, Хэрлэн 7-р баг, Номгон, Чандгана талд	Далхжав Алтанбагана /ДО76082611/	25	Эрх шилжүүлэх гэрээ
2	Далхжав Баттөр /ДО79080318/	Үр тарианы усалгаатай тариалан	772021 м2	Хэнтий, Хэрлэн 7-р баг Номгон, Чандгана талд	Далхжав Алтанбагана /ДО76082611/	25	Эрх шилжүүлэх гэрээ